



“Алтанбулаг” чөлөөт бүсийн 2017оны ажлын товч тайлан

I. Үйл ажиллагаа

Чөлөөт бүсийн үйл ажиллагааг эрчимжүүлж гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжиж ажиллана гэсэн 2016-2020 оны Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

2017 онд “Алтанбулаг” чөлөөт бүс Шадар сайдтай хийсэн үйл ажиллагааны төлөвлөгөө 95.2% биеллээ.

ОХУ-Монгол-БНХАУ-ын эдийн засгийн коридор байгуулах ажлын хүрээнд ГХЯ, ЗТЯ, бусад холбогдох яам, газруудтай болон ОХУ-ын төлөөлөгчийн газар, Хиагт боомтын удирдлагуудтай “Алтанбулаг” чөлөөт бүсээс ОХУ-руу орох гарц нээх, чөлөөт бүсээр транзит тээврийг дайран өнгөрүүлэх, аялал жуулчлалын бүс, хамтарсан логистикийн төв байгуулах талаар хамтран ажиллаж, ажлын уулзалтуудыг удаа дараа хийж байна.

Гадаадын иргэн, харъяатын газар, Гаалийн ерөнхий газар, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар, Татварын ерөнхий газарзэрэг төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах зорилгоор МҮХАҮТ-тай хамтарсан ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Үүний үр дүнд хөрөнгө оруулагчдын татварын хөнгөлөлт чөлөөлөлтийг хэрхэн эдлүүлэхийг ойлгомжтой болгож, Татварын ерөнхий газрын даргын 2017 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн “Тайлангийн маягт шинэчлэн батлах тухай” А/73 тушаалын 3-р хавсралт Маягт ТТ-026 “Хөнгөлөгдөх татвар болон чөлөөлөгдөх орлогын мэдээ”, Б. “Албан татвараас хөнгөлөх” хүснэгтийн 8, 9, 10-т, А.Албан татвараас чөлөөлөгдөх орлого”-ийн 15 тоот татварын маягтуудыг шинээр батлууллаа.



Гадаадын иргэн, харьяатын газар, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газруудтай хамтран ажиллах асуудлууд бүрэн шийдвэрлэгдсэн. Гаалийн ерөнхий газрын удирдлагуудын түвшний уулзалт зохион байгуулах боломж олдоогүйгээс шийдвэрлэгдээгүй асуудлууд үлдсэн.

“Алтанбулаг” чөлөөт бүсэд бүртгэлтэй 107 аж ахуйн нэгжээс “Чөлөөт бүс” тодотголтой хуулийн этгээд байгуулсан 51 ААН байна. Үүнээс 17 нь шинэчилсэн гэрээгээ байгуулаад байна.

55 компанийн 8,4 тэрбум төгрөгийн хувийн хөрөнгө оруулалт хийгдсэн. Чөлөөт бүсийн аж ахуйн нэгжүүдээс газрын төлбөр болон бусад хураамжаар нийт

1056,2 сая төгрөг үүнээс 2017 онд 52,9 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээд байна. 2017 оны төсвийн гүйцэтгэл 92.3% биелсэн.



Чөлөөт бүсэд бетон зуурмагийн үйлдвэрлэл, тавилгын худалдаа, арьс ширэн эдлэл, авто сэлбэгийн худалдаа, аялал жуулчлал болон худалдааны чиглэлээр 14 аж ахуйн нэгж үйл ажиллагаа эрхэлж байна.

2014 онд нээлтээ хийснээс хойш бүсэд 3,9 сая ам.долларын бараа бүтээгдэхүүн нэвтэрч, 2,8 сая ам.долларын барааг борлуулсан.


Чөлөөт бүсийн төсвийн (348) болон хувийн хөрөнгө оруулалтаар (322) хийгдсэн ажлуудыг гүйцэтгэх явцад 670 түр ажлын байр бий болгосон байна. Одоогоор үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн 18 байнгын ажлын байр байна.

Зорчигч тээврийн хэрэгслийн хөдөлгөөний мэдээ:

Он	Зорчигч			Тээвэр		
	Дотоод	Гадаад	Нийт	Дотоод	Гадаад	Нийт
2014 он	15620	426	16046	4854	112	4966
2015 он	16172	140	16312	3934	1	4336
2016 он	33880	180	34060	12369	28	12397
2017 он	29046	183	29229	12141	17	12158
Нийтдүн	94718	929	95647	33699	158	33857

Эндээс харахад гадаадын зорчигч, тээврийн хэрэгсэл ялангуяа ОХУ-ын иргэд, ААН-ийн тоо нэмэгдэхгүй байгаа нь төрийн байгууллагуудын уялдаа холбоо, хууль, журмуудын биелэлт, зөрчлүүдээс болж байна.

Бараа эргэлтийн мэдээ:



Энэ хугацаанд “Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газар хоорондын 20, 21 дүгээр комиссын хурлуудад “Алтанбулаг” чөлөөт бүсийн талаас хурлын протоколд дараах саналуудыг тусгаж ирсэн. “Бүс ба Зам” хөтөлбөрийн хүрээнд:

- Азийн авто замын сүлжээ /АН-3/-т холбох
- Цахилгаан эрчим хүчний өргөтгөлд хамруулах
- Төмөр замын төв коридор холбох г.м.

Байгууллагын дунд хугацааны стратеги төлөвлөгөөг “Бүс ба Зам” хөтөлбөрийн хүрээнд шинэчлэн боловсруулж, гадаад дотоодын хөрөнгө оруулагчдын үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор чөлөөт бүсийн вэб сайтыг байнгын идэвхтэй үйл ажиллагаанд монгол, англи, орос, хятад хэл дээр орчуулан ажиллуулж байна.

Байгууллагын лого-г Оюуны өмч, улсын бүртгэлийн газарт бүртгүүлж, гэрчилгээг авч баталгаажууллаа.

Чөлөөт бүсийн хуулийн 10.6-д заасны дагуу “Алтанбулаг” чөлөөт бүсийн үйл ажиллагаанд нэн шаардлагатай байгаа интернетийн шугам сүлжээ, хяналтын камеруудыг өөрсдийн боломж бололцоогоор бүсэд байршуулж сурталчилгааны самбаруудыг шинэчиллээ.

Гэрээний үүргээ биелүүлээгүй 6 аж ахуйн нэгжийн газар эзэмших эрхийг эхний ээлжинд цуцалж, газар олголтын асуудлыг цэгцэлж, газрын бүсчлэлийг шинэчлэн баталлаа. “Газар эзэмшүүлэх, төсөл сонгон шалгаруулалт” 2 удаа зохион байгуулан нийт 14 аж ахуйн нэгж төслөө ирүүлснээс 4-н ААН шалгарлаа.

2013 оны 8 дугаар сарын 2-ны Засгийн газрын 280 дугаар тогтоолоор батлагдсан “Гудамж зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам”-ын дагуу бүс доторхи хаягжуулалт хийхээр ажиллаж байна.

2017 оны 6-8 дугаар саруудад “Алтанбулаг” чөлөөт бүсэд шинээр баригдсан Захирагчийн ажлын албаны байрны гадна талын зам талбай, ногоон


байгууламжийг барьж, чөлөөт бүсийн сурталчилгааны ажлуудыг өөрсдийн ажилчдын хүч бололцоогоор хийлээ

“Алтанбулаг” чөлөөт бүсэд байрладаг нутгийн ард түмний сүсэглэдэг “Бүргэдэй хайрхан” уулын овоо тахилгыг сэргээн засварлаж чөлөөт бүсийн ажилчдын ажлын хариуцлагыг сайжруулах талаар олон төрлийн арга хэмжээнүүд явуулж, ажилчдыг ажлын багаж, өвөл зуны ажлын хувцастай болголоо.



II. Дэд бүтэц -2018 онд үргэлжлэл

Монгол Улсын Засгийн газраас 2016 оны 4 дүгээр улиралд 2004-2012 онуудад хийгдсэн болон дутуу хийгдсэн дэд бүтцийн ажлуудын санхүүжилт болох 3,4 тэрбум төгрөг олгосны үр дүнд чөлөөт бүсэд хийгдсэн 6 дэд бүтцийн ажил дуусч, 25 км бохир усны шугам, өргөлтийн насосны станцын ажлыг улсын комисс хүлээн авч, тохируулга угсралтын ажил 2018 оны 8 дугаар сард хийгдэж дуусахаар боллоо.



Улсын комиссоос хүлээн авсан дараах объектууд:

1. 800 м³ усан сангийн барилга, шугам хоолойн ажил /136 метр/
2. Бүсийн шалган нэвтрүүлэх байр
3. Бүсийн гадна цэвэр усны шугам хоолой, гүний 7худаг /11 км/
4. Бүсийн гадна цэвэр усны гүний худгийн цахилгаан хангамжийн шугам, тоноглолууд
5. Бүсийн доторхи гадна цэвэр, бохир усны шугам хоолой.
6. Алтанбулаг-Сүхбаатарын бохир усны шугам хоолой, 12 ш өргөлтийн насосны станц./25 км/
7. Алтанбулаг-Сүхбаатарын бохир усны шугам хоолойн өргөлтийн насосны станцын цахилгаан хангамжийн шугам, тоноглолууд /25 км/
8. Бүсийн доторхи цахилгаан хангамжийн түр шугам, дэд станц, тоноглолууд,

гэх мэт ажлуудыг орон нутагт нь мэргэжлийн байгууллагад шилжүүлж өгөхөөр удаа дараа албан бичиг явуулсан ч хөрөнгө мөнгө төсөвт суугаагүй шалтгаанаар хүлээн авахаас татгалзсаар байна.

III. 2018 онд шийдвэрлүүлэх асуудлууд

1. Дэд бүтцийн ашиглалтын албыг байгуулж 26,5 тэрбум төгрөгийн өртөг бүхий дэд бүтцийн ажлыг хариуцах эзэнтэй болгох шаардлагатай байна.

- 2014 онд чөлөөт бүс байнгын үйл ажиллагааны дэглэмд шилжсэнээс хойш өнөөдрийг хүртэл чөлөөт бүсийн ажилчид өөрсдийн хүч бололцоогоор дэд бүтцийн ашиглалтын ажлыг гүйцэтгэсээр ирлээ. Цаашид энэ ажлыг чөлөөт бүсийн захиргаа гүйцэтгэхэд хөрөнгө мөнгө, хүн хүч, техник шаардлагатай талаар 2017, 2018 оны төсөвт хөрөнгө мөнгийг нь тусгасан боловч шийдэгдээгүй. Энэ талаар Сэлэнгэ аймгийн захиргаа үйл ажиллагаа нь эхлээгүй, ашиглалтын зардал шийдэгдээгүй дэд бүтцийн ажлуудыг хүлээн авах боломжгүй гэсэн хариу өгсөн.

2. Ерөнхий төлөвлөгөөний дагуу одоо ашиглагдаж байгаа 110кВ-ын овортой баригдсан 25 км 35кВ-ын цахилгаан дамжуулах шугамыг 110кВ-д шилжүүлж чөлөөт бүсийн цахилгаан хангамжийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

- Хөрөнгө оруулагчдыг татах зорилгоор төсөл сонгон шалгаруулалт зарлахад импортыг орлосон экспортын бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор үйлдвэрийн бүсэд үйлдвэр, агуулах барих хөрөнгө оруулагчид өсөн нэмэгдэх хандлагатай байгаа бөгөөд үүний хэрээр цахилгаан эрчим хүчний хэрэглээ эрс нэмэгдэхээр байна.

3. Гаалийн ерөнхий газар Чөлөөт бүсийн тухай хуулийг хэрэгжүүлж, ойлголтын зөрүүг нэг болгож ажиллах шаардлагатай байна.

- Чөлөөт бүсийн тухай хуулийн 16.1.4-т ...**гадна** зорчигчийн худалдаж авсан 3.0 сая төгрөг хүртэл үнийн дүнтэй барааг **чөлөөт бүсээс гаалийн нутаг дэвсгэрт оруулахад** гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас **чөлөөлөх** гэж заасан хуулийн заалтыг хэрэгжүүлж ажиллах

- “Хүнсний тухай хууль”-ийн 11 дүгээр зүйлийн 11.1-д заасны дагуу чөлөөт бүс рүү импортлон оруулж ирсэн хүнсний бүтээгдэхүүнийг худалдан авалт хийж гаалийн нутаг дэвсгэрт гаргасан аливаа хүнсний бүтээгдэхүүнийг **дахин импортлох** гэж үзэхгүй байх

4. Ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, батлуулах шаардлагатай байна.

- 2004 онд хийгдсэн ерөнхий төлөвлөгөө 14 жил болж байгаа тул зайлшгүй шинэчлэх шаардлага үүсээд байна.

ЗАХИРАГЧИЙН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ж. АМАРЖАРГАЛ